



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар E/04

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу "Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу "Хүүхдийн мөнгө" олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Зохих журмын дагуу хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА

000000052



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай-6.
Утас 26-30-83. Факс 26-12-73
E-mail: Office@president.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ц.ЦОЛМОН ТАНАА

2018. 03. 12 № ТГ/212
танаий _____ -ны № _____ -т

Төсөл өргөн мэдүүлэх хугацаа
товлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт тус тус заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч "Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу "Хүүхдийн мөнгө олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж буй тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан баримт бичгийг хавсаргав.

Хавсралт 34 хуудастай.

ДАРГА



З.ЭНХБОЛД

0000001460



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20¹⁸. он... дугаар
сарын²⁰-ны өдөр

Дугаар/Хэг/
344

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн "Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж "Хүүхдийн мөнгө" олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

000206

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС


Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэлд:

"III. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга санаачлан боловсруулсан "Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мэнгэн тэтгэмж "Хүүхдийн мэнгэ" олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга санаачлан боловсруулсан "Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мэнгэн тэтгэмж "Хүүхдийн мэнгэ" олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1. Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж байгаа "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-т нийгмийн хамгаалал, халамжийг ядуу, амьжиргааны хувьд хүнд нөхцөлд амьдарч байгаа зорилтот бүлэгт чиглүүлэх, хүүхдийн мэнгэн тэтгэмжийг нийт хүүхдийн 60 хувьд буюу хүн амын орлого багатай бүлэгт олгох нөхцөл заасны дагуу Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар хүүхдийн мэнгэн тэтгэмж олгох зардалд 164.2 тэрбум төгрөгийг тусган баталж, зорилтот бүлгийн 684.0 мянган хүүхдэд хүүхдийн мэнгэн тэтгэмжийг олгож байна.

2. Засгийн газраас хүүхдийн мэнгэн тэтгэмжийг нийт хүүхдийн 80 хувьд олгох асуудлаар Олон улсын валютын сантай харилцан тохиролцоо ажиллаж байгаа болно." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ: МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Х.БАТТУЯГА

**МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД БҮРТ ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ БУЮУ
“ХҮҮХДИЙН МӨНГӨ” ОЯГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орж хүүхдийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй байх, түүнчлэн хүүхдийг гэр бүлийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшилийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчилахгүй байх зарчмыг хуульчлан мөрдөх үүрэг хүлээсэн. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд мөн иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заасан байдаг.

Үүний хүрээнд Монгол Улсын үе үеийн Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд бүрт хүртээмжтэй болгох, ялангуяа хүүхэд бүр ижил тэгш орчинд өсч хүмүүжих нэхцэлийг бүрдүүлэх талаар анхаарал тавин ажиллаж шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн бөгөөд эдгээр арга хэмжээний нэг нь хүүхэд, эцэг, эхчүүдийн дэмжлэгийг хүлээсэн, эдийн засгийн өсelt, хямралын аль ч үед хэрэгцээтэй гэдэг нь бодит амьдрал дээр нотлогдож, олон улсад сайн жишээгээр нэрлэгдсэн Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу хүүхэд бүрт олгож байсан “Хүүхдийн мөнгө”-ний бодлого юм.

Монгол Улс 2009 онд батлагдсан Хүний хөгжил сангийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу тухайн оноос хүүхдийн мөнгийг ямар нэг ялгаваргүйгээр олгож ирсэн боловч уг хуулийг Улсын Их Хурал 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгож, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүүхдийн мөнгө олгох арга хэмжээг нийгмийн халамжийн нэг төрөл болгон, хүүхдийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгох болсон.

Хүүхэд бүрийг эрх тэгш нэхцлөөр хангах, боловсрох, хүмүүжих, хөгжих нэхцэл боломжийг бий болгох агуулгатай, хүүхэд бүрт чиглэсэн, халамж, тэтгэмжийн гэхээсээ илүүтэй Монгол төрийн хүн амын бодлого гэж үзэж болох хүүхдийн мөнгөний бодлого өөрчлөгдсөн нь хүүхдийн нийгэмд эзлэх байр суурь, хөгжилд сэргэөр нөлөөлж болзошгүй нэхцэл байдлыг үүсгэж байна.

Хүүхдийн мөнгийг ийнхүү ялгаварлан олгох болсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан

тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэснийг, мөн Монгол Улс 1990 онд нэгдэн орсон НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасан хүүхдийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй байх, түүнчлэн хүүхдийг гэр бүлийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшлийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчилахгүй байх зарчмыг тус зөрчиж байна.

Харин Засгийн газраас төсвийн орлогын өсөлттэй холбогдуулан 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар бүх хүүхдэд хүүхдийн мөнгө олгох, хүүхдийн мөнгөө аваагүй хүүхдүүдэд нөхөж олгох шийдвэр гаргасан бөгөөд энэ нь хүүхдийг алагчилан, ялгаварласан төрийн алдаатай бодлогыг запруулсан, хүүхэд бүрт олгож ирсэн "Хүүхдийн мөнгө"-ний бодлого зөв болохыг нотолсон оновчтой шийдвэр болсон тул Монгол Улсын Засгийн газар Үндсэн хууль болон бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах чиг үүргийнхээ хүрээнд энэхүү бодлого шийдвэрээ тууштай баримталж, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газраас 2018 онд Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк, Японы ЖАЙКА байгууллагатай байгуулсан бодлогын баримт бичигт хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 60 хувьд олгохоор тусгаад гэрээ байгуулсан боловч Сангийн яам Засгийн газраас ОУВС-тай байгуулсан гэрээгээ өөрчлөх, нийт хүүхдийн 80 хүртэл хувьд хүүхдийн мөнгийг олгох боломжтой гэж мэдэгдсэн.

Монгол Улс 2018 онд нийт хүүхдийнхээ 60 хувьд хүүхдийн мөнгийг олгохоор тооцож улсын төсөв, нийгмийн халамжийн сангаас 164,160.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Хүүхдийн мөнгөний бодлогын гадна үлдэж байгаа нийт хүүхдийн 40 хувьд хүүхдийн мөнгө бүрэн олгох тохиолдолд 100 гаруй тэрбум төгрөг шаардагдах ба 2018 онд Монгол Улс нийт хүүхдүүдээ хамруулан хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт олгоход 266 тэрбум төгрөг шаардагдана.

Монгол Улсын Засгийн газар 2018 онд эдийн засгийн төлөв байдлыг зөрэгзэр харж байгаа, тиймээс татварын орлогын өсөлт, алт, зэс, нүүрс зэрэг голлох экспортын бүтээгдэхүүн, эрдэс, түүхий эдийн үнийн өсөлт зэргийг харгалзан "Хүүхдийн мөнгө"-ийг хүүхэд бүрт олгох бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

Түүнчлэн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд ч сайд, дарга нарын төсөв, төрийн албаны орон тоо, захиргааны нүсэр бүтцийн зардал, төрийн албан хаагчдад олгосон нэг удаагийн урамшуулал зэрэг зарим тэвчиж болох зардлыг танах замаар хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт 100 хувь олгох боломж Монгол Улсын төсөвт хангалттай байна гэж харж байна.

Нийгмийн шударга ёсны гажуудал, байгалийн баялгийн тэгш бус хуваарилалт улам гүнзгийрсэн өнөөгийн нөхцөлд хүүхдийн мөнгийг ойролцоо амьжиргааны түвшинтэй хүүхдүүдэд журам батлах замаар ялгавартайгаар олгох нь туйлаас буруу юм.

Иймд дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу "Хүүхдийн мөнгө" олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хүүхдийн мөнгийг нийгмийн халамж бус хүн амын бодлогынх нь хүрээнд авч үзэн "Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зэрчилгүй 0-18 хүртэлх насны Монгол Улсын иргэн бүрт 2018 онд сар бүр 20 000 /хорин мянга/ төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж /хүүхдийн мөнгө/ олгох, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоходо амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан нийт өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт олгох, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохтой холбогдуулан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, бусад шаардлагатай арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах талаархи зохицуулалтыг тусгасан.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэмд ямар нэгэн сөрөг үр дагавар гарагхуй бөгөөд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болох тухай Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, зохицуулалт болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц хэрэгжиж, хүүхдэд ээлтэй эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуултай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, холбогдох бусад хуултай нийцсэн болно.

---оОо---

ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу
“Хүүхдийн мөнгө” олгох тухай Улсын Их Хурлын
тогтоолын төслийн талаар*

Монгол Улсын үе үеийн Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд бүрт хүртээмжтэй болгох, ялангуяа хүүхэд бүр ижил тэгш орчинд өсч хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэх талаар анхаарал тавин ажиллаж шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн бөгөөд эдгээр арга хэмжээний нэг нь хүүхэд, эцэг эхчүүдийн дэмжлэгийг хүлээсэн, эдийн засгийн өсөлт, хямралын аль ч үед хэрэгцээтэй гэдэг нь бодит амьдрал дээр нотлогдож, олон улсад сайн жишээгээр нэрлэгдсэн Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу хүүхэд бүрт олгож байсан “Хүүхдийн мөнгө”-ний бодлого юм.

Монгол Улс 2009 онд батлагдсан Хүний хөгжил сангийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу тухайн оноос хүүхдийн мөнгийг ямар нэг ялгаваргүйгээр олгож ирсэн боловч уг хуулийг Улсын Их Хурал 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгож, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүүхдийн мөнгө олгох арга хэмжээг нийгмийн халамжийн нэг төрөл болгон, хүүхдийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгох болсон. Ингэснээр хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан амьжиргааны түвшний оноо нь 502, 567 босго онооноос доош байгаа өрхийн хүүхдэд 2017 оны 6 дугаар сарыг хүртэлх хугацаанд олгосон бөгөөд 2018 оны 01 дүгээр сараас эхлэн 554,0 босго онооноос доошии өрхийн хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгож байна.

Харин төсвийн орлогын өсөлттэй холбогдуулан Засгийн газраас 2017 оны 7 дугаар 04-ний өдрийн хуралдаанаар өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан өрхийн бүх хүүхдэд өрхийн амьжиргааны түвшний оноо харгалзахгүйгээр хүүхдийг мөнгөн тэтгэмжийг 2017 оныг дуустал олгосон бөгөөд энэ нь хүүхдийг алагчилан, ялгаварласан териин алдаатай бодлогыг запруулсан, хүүхэд бүрт олгож ирсэн “Хүүхдийн мөнгө”-ний бодлого зөв болохыг нотолсон оновчтой шийдвэр болсон тул Монгол Улсын Засгийн газар Үндсэн хууль болон бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах чиг үүргийнхээ хүрээнд энэхүү бодлого шийдвэрээ тууштай баримталж, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын нийт хүүхдийг өмч хөрөнгө, өрхийн мэдээллийн судалгааг үндэслэн эд хөрөнгийн байдал, нийгмийн гарлаар нь ялгаварлан хүүхдийн мөнгийг олгох, олгохгүй гэж ангилан хувааж буй нөхцөл байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэснийг, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ НҮБ-ын “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийн холбогдох заалтыг тус тус зөрчиж байна.

Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу "Хүүхдийн мөнгө" олгох тухай тогтоолын төсөлд дараахь зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1.Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй 0-18 хүртэлх насны Монгол Улсын иргэн бүрт 2018 онд сар бүр 20 000 /хорин мянга/ төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж /хүүхдийн мөнгө/ олгохоор;

2.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоходо өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан нийт өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт олгохоор;

3.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохтой холбогдуулан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, бусад шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгахаар тус тус тусгасан.

Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу "Хүүхдийн мөнгө" олгох тухай тогтоолын төслийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан ёсны цахим хуудсаар 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 5-ны өдөр хүртэл иргэд, олон нийтээс санал авсан болно. Иргэд хүүхэд бүрт ямар нэг ялгаварлалгүйгээр хүүхдийн мөнгийг өгөхийг дэмжсэн санал ирүүлсэн бөгөөд саналыг төсөлд хавсаргав.

---оОо---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... сарын ... өдөр

Дугаар...

Төрийн ордон, Улаанбаатар хот

Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж “Хүүхдийн мөнгө” олгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй 0-18 хүртэлх насны Монгол Улсын иргэн бүрт 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр 20 000 /хорин мянга/ төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж /хүүхдийн мөнгө/ олгосугай.
2. Энэ тогтоолын 1-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохдоо өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан нийт өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр 20 мянган төгрөгийг олгосугай.
3. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохтой холбогдуулан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, бусад шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу Хүүхдийн мөнгө олгох тухай асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлон, тухайн асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудыг илрүүлж, тэдгээрийн зэрэг болон сөрөг талуудыг харьцуулан судалж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг шийдвэр гаргагчид санал болгох юм.

Урьдчилан тандаж судлах ажлыг дараах үе шаттайгаар хийнэ:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Зорилгыг томьёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, сонгох;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандаж судлах;
5. Хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх, зөвлөмж боловсруулах гэсэн бүтэц, дараалалтайгаар хийж гүйцэтгэнэ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1.1. Асуудлыг тодорхойлж, нарийвчлан томьёолох:

Монгол Улсын ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэн, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн, иргэддээ тэгш хүртээх зорилгоор Их Хурлаас 2009 онд “Хүний хөгжил сангийн тухай” хуулийг баталж, энэхүү хуулийн хүрээнд Монгол Улс хүүхэд бүрт хүүхдийн мөнгийг ямар нэг ялгаваргүйгээр олгож ирсэн боловч уг хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болж, Улсын Их Хурал 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хүүхдийн мөнгө олгох арга хэмжээг нийгмийн халамжийн нэг төрөл болгон, хүүхдийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгох болсон.

Ингэснээр “Хүүхдийн мөнгө олгох тухай” Засгийн газрын журамд зарим нэг өөрчлөлт орон хүүхдийн мөнгийг “Хүний хөгжил сан”-гаас санхүүжүүлдэг байсныг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр зохицуулж, хүүхдийн мөнгийг Өрхийн мэдээллийн нэгдсэн сан (ӨМНС)-гийн амьжиргааны түвшний 502, 567 босго онооноос дээш өрхийн хүүхдэд олгохооргүй болсон.

Хүүхдийн мөнгийг халамжийн нэг төрөл болгон, хүүхдийг өмч хөрөнгө, эд хөрөнгийн байдал, нийгмийн гарлаар нь ялгаварлан хүүхдийн мөнгийг олгож буй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалт, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хүүхдийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон

бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй байх, түүнчлэн хүүхдийг гэр булийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшилийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчилахгүй байх тухай зохицуулалтуудтай тус тус зөрчилдөж байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Хүүхдийн мөнгийг халамжийн нэг төрөл болгон, хүүхдийг өмч хөрөнгө, эд хөрөнгийн байдал, нийгмийн гарлаар нь ялгаварлан хүүхдийн мөнгийг олгож буй нь дор дурдсан тодорхой бүлэг хүүхдийн эрх ашигт сөрөгөөр нөлөөлж байна.

Эрх, ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
Нийгмийн гарал, байдлаараа ялгаварлагдан хүүхдийн мөнгө авах боломжгүй болж байгаа нийт хүүхдийн 40% буюу 373.000 орчим хүүхэд	Хүүхэд бүрийг эрх тэгш нөхцлөөр хангах, боловсрох, хүмүүжих, хөгжих нөхцөл боломжийг бий болгох агуулгатай, хүүхэд бүрт чиглэсэн, халамж, тэтгэмжийн гэхээсээ илүүтэй Монгол төрийн хүн амын бодлого юм. Гэтэл тодорхой бүлэг хүүхэд гэр булийн байдал, эд хөрөнгө, нийгмийн гарал байдлаар ялгаварлагдаж байна.

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас нийгэмд “хүүхдийг алгачилсан, халамжийн мөнгө авдаг, авдаггүй, халамжийн болон халамжийн бус хүүхэд гэж ялгаварлан гадуурхагдах” сөрөг нөхцөл байдал үүсч болзошгүй байна.

1.3. Асуудал үүсгэж буй шалтгааныг тодорхойлох:

Улсын Их Хурлаас 2009 онд “Хүний хөгжил сангийн тухай” хуулийг баталж, энэ хуулийн хүрээнд Монгол Улс хүүхэд бүрт хүүхдийн мөнгийг ямар нэг ялгаваргүйгээр олгож ирсэн боловч уг хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болж, Улсын Их Хурал 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүүхдийн мөнгө олгох арга хэмжээг нийгмийн халамжийн нэг төрөл болгосон, улмаар Засгийн газрын журамд өөрчлөлт орж, гэр бүлийнх нь амьжирагааны түвшний босго онооноос хамааран хүүхдэд хүүхдийн мөнгө олгох эсэх асуудал шийдвэрлэгддэг болж, хүүхэд бүр хүүхдийн мөнгө авч чадахгүй байна.

ХОЁР. ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ

Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн тул хүүхдийн мөнгийг нийт хүүхдэд олгох, энэ чиглэлээр эрх зүйн

орчинг сайжруулах шаардлагатай байна. Иймд хууль, тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу зорилтыг “Хүүхдийн мөнгийг нийт хүүхдэд олгох эрх зүйн орчинг бүрдүүлэх” гэж томьёолж болно.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, СОНГОХ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбарыг тогтоож, хувилбарыг харьцуулан судлав. Үүнд:

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Тулгамдаж буй асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй ч, асуудал шийдэгдэхгүй юм.	Үр дүн серөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Нийгмийн зүгээс төрд хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт олгох шахалтыг сайн үзүүлж магадгүй боловч Зорилыг хангахгүй, тулгамдаж буй асуудал хэвээр үргэлжилнэ.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Гэхдээ асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгаж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрч чадахгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Тулгамдаж буй асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгаж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс мөнгөн дэмжлэг нэг удаадаа үзүүлж болох ч хүүхдийн мөнгийг байнга олгох зорилгод хүрч чадахгүй	нэг удаагийн шинжтэй тул асуудал цаашид дахин үргэлжилнэ.	Тодорхой үр дүнд хүрч чадахгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Тулгамдаж буй асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгаж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй

6	Захиргааны шийдвэр, тогтоол, эрх зүйн акт гаргах	Улсын Их Хурлын тогтоол гаргаж, засгийн газарт чиглэл өгөх боломжтой. Ингэснээр хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд өгөх боломж нээгдэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой юм.	Улсын Их Хурлын тогтоолийн төсөл боловсруулахад төдийлөн өндөр захиргааны зардал гарахгүй харин хүүхдийн мөнгө олгогдохгүй байгаа 40 хувьд нэмж мөнгө олгох шууд зардал үүсэх юм.	Үр дүнтэй.
7	Хуулийн төсөл боловсруулах	УИХ-аас хууль батлах замаар хүүхэд бүрт сар бүр хүүхдийн мөнгө олгох боломжтой ба зорилгод хүрэх боломжтой байна.	Терийн байгууллагын хүний нөөцийн зардал нэмэгдэхгүй бөгөөд харин улсын төсөвт хүүхдийн мөнгөтэй холбоотой зардал нэмэгдэнэ.	Үр дүнтэй.

Харьцуулалтын үр дүнг харгалзан үзвэл дараах 2 хувилбар илүү зөрөг үр нөлөөтэй байх магадлалтай байна:

Хувилбар 1: Улсын Их Хурлаас тогтоол гаргах замаар Засгийн газарт чиглэл өгч Хүүхэд бүрт хүүхдийн мөнгө олгох,

Хувилбар 2: Улсын Их Хурлаас тусдаа бие даасан хууль батлах замаар хүүхдийн мөнгийг сар бүр олгох.

Дээрх хоёр хувилбарыг харьцуулан авч үзвэл Улсын Их хурлаас тогтоол батлах замаар Засгийн газарт чиглэл өгч, хүүхэд бүрт сар бүр хүүхдийн мөнгө олгох нь цаг хугацааны хувьд хэмнэлттэй, захиргаа, хүний нөөцийн зардал харьцангуй бага байх тул зорилгод хүрэхийн тулд Улсын Их Хурлаас тогтоол гаргаж асуудлыг шийдвэрлэх хувилбар нь илүү үр дүнтэй боломжит хувилбар гэж үзлээ.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газраас баталсан аргачлалын дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаралаа.

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:

Хүүхдийг өмч хөрөнгө, эд хөрөнгийн байдал, нийгмийн гарлаар нь ялгаварлан хүүхдийн мөнгийг олгож буй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалт, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хүүхдийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй байх, түүнчлэн хүүхдийг гэр булийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчилахгүй байх гэсэн заалттай зөрчилдэж байсныг арилгах бөгөөд ямар нэгэн байдлаар хүний эрх, ялангуяа хүүхдийг эрхийг зөрчсөн, ялгаварласан нөхцөл байдлыг үсгэхгүй юм.

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

Сонгосон хувилбар нь боловсруулж хэрэгжүүлэхэд УИХ-аас тогтоол гаргах ба тогтоолыг боловсруулахад хуультай харьцуулахад хүний нөөцийн зардал, цаг хугацааны хувьд харьцангуй бага зардал гарах юм. Одоо хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 60 хувьд нь олгож байгаа бөгөөд хүүхдийн мөнгө олгох механизм, арга туршлага нь нэгэнт бий болсон байх тул нэмж төрөөс нэмэлт зардал гарахгүй юм. Харин нийт хүүхдүүдэд хүүхдийн мөнгө олгодог болсноор улсын төсөвт ирэх шууд зардал өсөх юм.

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Сонгосон хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцтой нийцүүлж байгаа.

ТАВ. ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

Хүүхдийн мөнгийг өмч хөрөнгө, эд хөрөнгийн байдал, нийгмийн гарлаар нь ялгаварлан олгож буй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалт, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хүүхдийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд

хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй байх, түүнчлэн хүүхдийг гэр бүлийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшилийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчилахгүй байх гэсэн заалттай тус тус зөрчилдэх байгаа тул энэхүү зөрчлийг арилгаж бүх хүүхдэд ямар нэгэн ялгаварлалгүйгээр хүүхдийн мөнгийг олгох эрх зүйн зохицуулалт бий болгохыг энэхүү тандан судалгаагаар зорьлоо.

Судалгааны үр дүнд Улсын Их Хурлаас тогтоол гаргах байдлаар бүх хүүхдэд хүүхдийн мөнгө олгох нь цаг хугацаа, зардал, асуудлыг шийдвэрлэх боломжийн хувьд үр дүнтэй хувилбар гэж үзлээ.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бурдуулсан эсэх	Тийм	Үгүй
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдж буй, эсхүл хөндөгдж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиулэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй
	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний	Тийм	Үгүй
3. Эрх агуулагч			

МОНГОЛ УЛСЫН ХУУХЭД БҮРТ ХУУХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ БЮОУ
“ХУУХДИЙН МӨНГӨ” ОЛГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛОЫН ТӨСӨЛ

	эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх 3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагчхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй
Үүрэг хүлээгч 4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх 5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх 5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бурдүүлэх эсэх	Тийм	Үгүй
		Тийм	Үгүй
		Тийм	Үгүй

**ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)**

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх 1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) 1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх 2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх 2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх 2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх 3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх 3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх 3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх 3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй
5.Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД БУРТ ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ БУЮУ
“ХҮҮХДИЙН МӨНГӨ” ОЛГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛОЛЫН ТЕСЕЛ

	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн тесөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нелөөлөх эсэх	Тийм	Үгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын тесөвт нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй
10.Макро здийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдал нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмерийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмер эрхлэгчдэд нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нелөөлөх эсэх	Тийм	Үгүй

**МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД БҮРТ ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ БУЮУ
“ХҮҮХДИЙН МӨНГӨ” ОЛГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛОЫН ТӨСӨЛ**

2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	4.3.Төрийн захирагааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас бааралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил зээмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй

	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нелөөлөх эсэх	Тийм	Үгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нелөөлөх эсэх	Тийм	Үгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нелөө:	Холбогдох асуултууд	Хариулт	
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй
	2.2.Эрчим хүчиний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй
	2.3.Эрчим хүчиний ўйлдвэрлэлд нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сергээр нелөөлөх эсэх	Тийм	Үгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сергээр нелөөлөх эсэх	Тийм	Үгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сергээр нелөөлөх эсэх	Тийм	Үгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцдөд сергээр нелөөлөх эсэх	Тийм	Үгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй
	4.3.Ундны усны чанарт нелөөлөх эсэх	Тийм	Үгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нелөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй
7.Нехэн сэргээгдэх/нехэн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нехэн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нехэн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй
	7.2.Нехэн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй

---Оо---

ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО¹

1. Эрх зүйн зохицуулалт

Хууль: Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд Нийгмийн халамжийн тэтгэмжийн төрлийг тусгасан бөгөөд 13 дугаар зүйлийн 13.1.5-д "хүүхдийн мөнгөн тэтгэмж" гэж заан, Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох олгох журмыг Засгийн газар батлахаар тусгажээ.

УИХ-ЫН ТОГТООЛ: УИХ-ын 2016.11.10-ны "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох талаар авах зарим арга" тухай 63 дугаар тогтоолоор Монгол Улсын 0-18 насны хүүхэд бурд олгох мөнгөн тэтгэмжийг зохион байгуулж олгохыг Монгол Улсын Засгийн газарт даалгахдаа Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур эрэмбэлэгдсэн өрхийн хүүхэд бурд сар бүр бэлэн мөнгөөр олгох гэж заасан.

Засгийн газрын тогтоол: Засгийн газрын 2017.01.18-ны "Журам батлах, журамд өөрчлөлт оруулах тухай" тухай 18 дугаар тогтоолын хавсралтаар "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг баталсан.

2. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ

Засгийн газрын 18 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам" дахь холбогдох зохицуулалт	Үргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ
1.2. Хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд (цаашид "хүүхэд" гэх), эсхүл түүнийг төлөөлөх хууль ёсны эрх бүхий Монгол Улсын иргэнд олгоно.	Хөдөлмөр, халамжийн Үйлчилгээний ерөнхий газар	<ul style="list-style-type: none">- нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын болон Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хэвийн ажиллуулах, тухай бүр шинэчлэх- Өргөдлийн маягтын загвар батлах- Хүүхдийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг хариуцах
2.3. Банкны ажилтан нь энэхүү журмын 2.2.1-2.2.3-т заасан баримт бичгийг хүлээн авч өргөдлийн маягтыг цахим хэлбэрээр бөглөн хүсэлт гаргасан иргэнээр гарын үсэг зуруулж баталгаажуулан, хүсэлтийг хүлээн авсан хугацааг өргөдөл тодорхой бичнэ. Өргөдлийн маягтыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.		
2.8. Банкнаас ирүүлсэн хүүхдийн мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.		

¹ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу боловсруулав.

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДЭД БҮРТ ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ БУЮУ
“ХҮҮХДИЙН МӨНГӨ” ОЛГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2.9. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шинээр төрсөн, нас барсан, харьяатаас гарсан зэрэг 0-18 хүртэлх насын хүүхдийн регистрийн дугаар, овог, нэр, оршин суугаа хаягийн мэдээллийг сар бүрийн 5-ны дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	Оюуны ёмч, Улсын бүртгэлтийн ерөнхий газар	<ul style="list-style-type: none"> - шинээр төрсөн, нас барсан, харьяатаас гарсан зэрэг 0-18 хүртэлх насын хүүхдийн регистрийн дугаар, овог, нэр, оршин суугаа хаягийн хүргэх.
2.11. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэхүү журмын 2.7-д заасан мэдээллийг энэхүү журмын 2.9-т заасан мэдээлэлтэй тулган шалгаж баталгаажуулан хүүхдийн мөнгө олгох хүүхдийн нэrsийн жагсаалтыг тухайн сарын 15-ны дотор Монголбанк болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Төрийн сангийн газар (цаашид “Төрийн сангийн газар” гэх)-т цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийг тулган шалгах, баталгаажуулах, албан бичиг хүргүүлэх
2.12. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн хүүхдийн мөнгө олгох хүүхдийн нэrsийн жагсаалтын мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг Монголбанк хариуцна.	Монгол банк	<ul style="list-style-type: none"> - хүүхдийн нэrsийн жагсаалтын мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг хариуцан ажиллах
2.13. Төрийн сангийн газар нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн хүүхдийн мөнгө олгох хүүхдийн нэrsийн жагсаалтыг үндэслэн холбогдох санхүүжилтийг Төрийн сан дахь нийгмийн халамжийн санд байршуулж зарцуулах эрхийг нээнэ. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санхүүжилтийг Төрийн сан дахь нийгмийн халамжийн сангийн данснаас Монголбанк дахь хүүхдийн мөнгөний тусгай дансанд байршуулна.	Монгол банк, Сангийн яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	<ul style="list-style-type: none"> - хүүхдийн мөнгө олгох хүүхдийн нэrsийн жагсаалтыг үндэслэн холбогдох санхүүжилтийг Төрийн сан дахь нийгмийн халамжийн санд байршуулж зарцуулах эрхийг нээх - санхүүжилтийг Төрийн сан дахь нийгмийн халамжийн сангийн данснаас Монголбанк дахь хүүхдийн мөнгөний тусгай дансанд байршуулах
2.18. Монголбанк хүүхдийн мөнгө олгож байгаа банктай сар бүр тооцоо нийлж, мөнгө олгосон нэrsийн жагсаалтыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүрийн 25-ны дотор цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.	Монгол банк	<ul style="list-style-type: none"> - хүүхдийн мөнгө олгож байгаа банктай сар бүр тооцоо нийлэх, - мөнгө олгосон нэrsийн жагсаалтыг цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлэх

<p>2.19. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн мөнгөний олголт, зарцуулсан хөрөнгийн мэдээг дараа сарын 4-ний дотор санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.</p> <p>3.9. Тухайн өрхийн амжиргааны түвшний оноо нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан босго шугамаас доогуур байгаа тохиолдолд хүүхдэд нийгмийн халамжийн сангаас сар бүр хүүхдийн мөнгийг бэлэн мөнгөөр олгох ажлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.</p> <p>3.10. Тухайн өрхийн амжиргааны түвшний оноо нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан босго шугамаас дээш байгаа тохиолдолд хүүхдийн мөнгийг бэлэн бусаар олгох хүүхдийн нэрсийн жагсаалтыг сар болон жилээр гаргаж, цахим хэлбэрээр төсөв, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанкинд хүргүүлнэ. Бэлэн бусаар авах өрхийн хүүхдийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.</p> <p>4.1. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг зогсоо шийдвэр гаргана:</p> <p>4.2. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг түр зогсоо шийдвэр гаргана:</p>	<ul style="list-style-type: none"> - хүүхдийн мөнгөний олголт, зарцуулсан хөрөнгийн мэдээг гаргах, мэдээг хүргэх - Өрхийн амжиргааны түвшний оноо нь босго шугамаас доогуур байгаа тохиолдолд хүүхдэд нийгмийн халамжийн сангаас сар бүр хүүхдийн мөнгийг бэлэн мөнгөөр олгох - босго шугамаас дээш байгаа тохиолдолд хүүхдийн мөнгийг бэлэн бусаар олгох хүүхдийн нэрсийн жагсаалтыг сар болон жилээр гаргах, цахим хэлбэрээр холбогдох байгууллагуулал хүргүүлэх. - Бэлэн бусаар авах өрхийн хүүхдийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх - Хүүхдийн мөнгө олгохыг зогсоо, түр зогсоо шийдвэр гаргах
---	--

3. Ажил, үйлчилгээ гүйцэтгэх хүний нөөцийн хэрэгцээ

Хүүхдэд мөнгөн тэтгэмж олгоход төрийн байгууллагын зүгээс гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг дээрх хэсэгт холбогдох төрийн байгууллага тус бүрийн гүйцэтгэх үүрэг болон ажил, үйлчилгээг нарийвчлан авч үзлээ. Үүнээс үзэхэд хүүхдийн мөнгө олгох үйл ажиллагаа нь Засгийн газрын 2017.01.18-ны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ын дагуу хэрэгжиж байгаа үйл ажиллагаа бөгөөд зөвхөн босго шугамаас доогуур өрхийн хүүхдэд гэж ялгаварлалгүйгээр Монгол Улсын нийт хүүхдэд олгоход төрийн байгууллагад нэмэлт хүний нөөцийн зардал гарахгүй болно. Учир нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа энэхүү журмын дагуу хүүхдийн мөнгө олгох ажиллагаа нь арилжааны банкаар дамжин хэрэгжиж байгаа бөгөөд төрийн байгууллагын зүгээс холбогдох бүртгэл, мэдээллийн сан үүсгэх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх, мөнгөний тусгай санд мөнгөн

**МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД БҮРТ ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ БУЮУ
“ХҮҮХДИЙН МӨНГӨ” ОЛГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТЕСӨЛ**

хөрөнгийг байршуулах, банкуудад шилжүүлэх, банкуудтай тооцоо нийлэх зэрэг үйл ажиллагааг холбогдох байгууллагын албан тушаалтан хариуцан хэрэгжүүлж байна. Иймд зардлын тооцоог бодит зардал буюу нийт хүүхдэд олгох зардлаар тооцон гаргах нь зүйтэй байна.

4. Зардлын дүнг тооцох

Монгол Улсын 0-18 насны нийт 1,042,000 хүүхдэд сар бүр 20,000 төгрөг олгохоор тооцоход 1 сард 20 тэрбум 840 сая, нэг жилд 250 тэрбум 80 сая төгрөгний зардал гарахаар байна. Энэ нь Засгийн газраас 2018 онд нийт хүүхдийн 60 хувьд олгох хүүхдийн мөнгөний төсвийн зардлын тооцоополд дурдсанаас 85 тэрбум 920 сая төгрөгний нэмэлт зардал гарахаар байна.

---оо---

ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА

Нэг. Судалгааны зорилго

Монгол Улсын хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу Хүүхдийн мөнгө олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үр нөлөөг үнэлж, тогтоолын төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, Улсын Их Хурлын тогтоолыг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар тогтоолын төслийн хэрэгжих боломж, зардлыг тооцоход чиглэсэн зөвлөмж өгөх зорилготой.

Судалгааг бие даасан байдлаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Судалгааны үе шат

Үр нөлөөг үнэлэх ажлын үе шат:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох
- УИХ-ын тогтоолын төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох
- Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх

Шалгуур үзүүлэлтийг сонгох үе шат:

Энэхүү үе шатанд тогтоолын төслийн, тодорхой хэсгийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгоно. Үүнд дараах шалгуур үзүүлэлтууд байна:

- Зорилгод хүрэх байдал
- Практикт хэрэгжих боломж
- Ойлгомжтой байдал
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- Зардал
- Харилцан Уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, тогтоолын төслийн үндсэн зорилго нь хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт сар болгон өгөх төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд тогтоолын төслийн үзэл баримтлалтай танилцаж, тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, тогтоолын төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдэг өмнө нь практикт амжилттай хэрэгжиж байсан тул сонгон авсан болно.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтад шууд хамаарах иргэн, хуулийн этгээд зохицуулалтыг шууд хүлээн зөвшөөрөх үү, үгүй юу гэдгийг шалгахын тулд сонгон авч дүгнэлт хийсэн болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг тогтоолын төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь төрийн байгууллага, хуулийн этгээдэд холбогдох зардал үүсгэхээр зохицуулсан байх тул уг хоёр субъектэд үүсэх зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоогоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг бүхэлд нь Нийгмийн халамжийн тухай хууль, Төсвийн тухай хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

Тогтоолын төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох үе шат:

Тогтоолын төслийн тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг нь үнэлнэ. Тогтоолын төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоохдоо шууд үр дагавар үүсгэж байгаа ач холбогдолтой зохицуулалтыг олж тогтоодог.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 4 зүйлтэй байх бөгөөд үүнээс “Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй 0-18 хүртэлх насны Монгол Улсын Иргэн Бүрт 2018 онд сар бүр 20000 төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохоор тогтоосугай” гэсэн хэсэг нь гол ач холбогдол бүхий заалт байна. Иймд тогтоолын төслийн энэ заалтыг сонгон авч төслийн үр нөлөөний судалгаа хийлээ.

Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх үе шат:

Энэ үе шатанд шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийн үр нөлөөг үнэлнэ. Үүнд:

№	Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх

2	Практикт хэрэгжих боломж	Практикт турших
3	Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
4	Хүлээн зөвшөөрөгдхөн байдал	Хүлээн зөвшөөрөгдхөн байдлын судалгаа хийх
5	Зардал	Зардлын тооцоо хийх
6	Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Шалгуур үзүүлэлтийн дагуу шалган судалсан байдал

Зорилгод хүрэх байдал:

Зорилгод хүрэх байдал нь тухай тогтоолын төслөөр тавьж байгаа зорилгодао хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр 20 мянган төгрөг олгох нь ямар зорилготой вэ? Тогтоолын төлсийн үзэл баримтлалаас үзвэл хүүхдэд олгох буй энэхүү мөнгийг Монгол Улсын халамж, тэтгэмжийн бодлого гэхээсээ илүү хүүхэд бүрийг эрх тэгш, нөхцөлөөр хангах, боловсрох, хүмүүжих, хөгжих нөхцөл боломжийг бий болгох агуулгатай, хүүхэд бүрт чиглэсэн Монгол төрийн хүн амын бодлого гэж үзсэн байна. Аливаа арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлэх нэг хөшүүрэг нь эдийн засгийн хувьд дэмжих арга мөн бөгөөд тухайлбал өмнө нь шинээр гэр бүл болсон айл өрхөд 500 мянган төгрөг өгдөг байсан нь 1 жилд 50,000 хос гэрлэлтээ бүртгүүлэх хөшүүрэг болсон байна. Эхийн төрөлтийг дэмжих нэг хөшүүрэг нь эдийн засгийн хөшүүрэг байх нь гарцаагүй ч хүүхэд бүрт 20 мянган төгрөг өгөх нь эдийн засгийн хувьд хэр зэрэг зорилгодао хүрсэн хөшүүрэг болох талаар Статистикийн ерөнхий газраас хүүхэд бүрт 20 мянган төгрөг олгож эхэлсэн 2009 оноос хойшхи эхийн төрөлтийн статистик тоон мэдээг авч судлах шаардлагатай байна.

Практикт турших

Энэ шалгуур үзүүлэлтээр тогтоолын төслийн зохицуулалттай холбоотой тодорхой тохиолдлыг бий болгож, туршилт явуулдаг. Практикт турших нь тухайн тогтоолын төсөл хэрэгжих боломжтай байна уу, тогтоолыг хэрэгжүүлэх байгууллагууд түүнийг хүлээн зөвшөөрч байна уу, бусад этгээдэд хэрхэн нөлөөлж байгаа болон тухайн зохицуулалтын хийдэл, зөрчлийг тогтооход чухал ач холбогдолтой байдаг.

Хүний хөгжил сангийн тухай хууль нь 2009 онд батлагдсан бөгөөд 2017 оны 1 дүгээр сарын 1 хүртэл хэрэгжсэн байдаг. Энэ хугацаанд хүүхэд бүрт сар бүр 20 мянган төгрөг олгож байсан бөгөөд практикт туршигдсан хөтөлбөр, арга хэмжээ юм. Одоо ч энэ арга хэмжээ нийт хүүхдийн 60 хувьд нь үргэлжлүүлэн олгож байгаа бөгөөд практикт 100 хувь хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн мөнгийг олгох тал дээр төрийн байгууллагуудад туршлага суусан байгаа.

Ойлгомжтой байдлыг шалгах

Энэ шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт тухайн төслийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томьёологдсон эсэхийг шалгаж тогтоодог.

Улсын Их Хурлын тогтоолоос сонгон авсан “Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй 0-18 хүртэлх насны Монгол Улсын Иргэн Бүрт 2018 онд сар бүр 20000 төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохоор тогтоосугай” гэсэн заалт нь ойлгомжгүй, хоёрдмол утга санаа агуулаагүй, товч тодорхой, ойлгомжтой байдлаар томьёологдсон байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Тухайн төсөл нь тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгасан бол хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийдэг.

Тогтоолын төслийн хувьд иргэд, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх зохицуулалт байхгүй бөгөөд иргээдэд зэрэг нелөөлөл бүхий зохицуулалт хийгдсэн учраас хүлээн зөвшөөрөх байдлын хувьд өндөр юм. Харин Хүүхдийн мөнгийг 100 хувь олгодог болгосноор Монгол Улсын төсөвт ирэх ачаалал нэмэгдэх нь зайлшгүй.

Зардлын тооцоо хийх

Тухайн тогтоолын төсөл батлагдсан тохиолдолд иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт үүсгэх зардал, ачааллыг тооцож хэрэгжүүлэх субъектэд зардал, ачаалал бага үүсгэх зохицуулалты хувилбарыг боловсруулдаг.

Тогтоолын төслийн хувьд иргэн, хуулийн этгээдэд зардал үүсгэх, ачаалал үзүүлэх зохицуулалт үүсэхгүй бөгөөд харин улсын төсөвт ирэх ачаалал нэмэгдэх нь зайлшгүй байна. Нийт хүүхдийн 60 хувьд хүүхдийн мөнгийг олгоход улсын төсөв, нийгмийн халамжийн сангаас 164,160 сая төгрөг зарцуулах тооцоо байна. Улсын Их Хурлын тогтоолийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцооллыг тогтоолын төслийн зардлын тооцооллын судалгаанаас дэлгэрэнгүй үзнэ үү.

Тогтоолын төслийн уялдаа холбоог шалгах

Хүүхдийг өмч хөрөнгө, өрхийн мэдээллийн судалгааг үндэслэн эд хөрөнгийн байдал, нийгмийн гарлаар нь ялгаварлан хүүхдийн мөнгийг олгож буй нь Монгол Улсын үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалттай зөрчилдөнө гэж үзэж байна.

Тогтоолын төслийн уялдаа холбоог шалгах хүрээнд дараахь асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоолоо:

	Шалгах асуултууд	
--	------------------	--

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД БҮРТ ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ БУЮУ
“ХҮҮХДИЙН МӨНГӨ” ОЛГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

1	Төслийн зохицуулалт тухайн тогтоолын зорилттой нийцэж байгаа эсэх?	Тогтоолын төслийн үзэл баримтлалд заасан зорилготой тогтоолийн төсөл нийцэж байна.
2	Хуулийн төслийн хууль тогтоомж гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх?	нийцэж байгаа
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх?	нийцэж байгаа
4	Хуулийн төслийн зүйл заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх?	Зерчилдсөн зүйл заалт байхгүй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх?	Бусад хуулийн зүйл заалттай давхардсан зүйл байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх?	Засгийн газарт үүрэг хүлээлгэсэн.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх?	Орхигдуулсан зохицуулалт байхгүй, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулахыг даалгасан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх?	Чиг үүрэг давхардуулсан зүйл байхгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Арилжааны банктай хамтран ажиллаж, гүйцэтгэнэ.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Албан татвар, хураамж, төлбөр тогтоосон зүйл байхгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх?	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал үүсгэхгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх?	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй. эерэг үр дагавар бүхий зохицуулалттай.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх?	жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, хүйсийн ялгаварлал байхгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?	Байхгүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий	Байхгүй

	боловсруулсан тусгасан эсэх?	
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зерчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх?	Засгийн газарт үүрэг болгосон.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараахь заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага		
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал	
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлагыг хангасан. Уялдсан байгаа.	
29.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тухайн асуудлыг зохицуулах нийгмийн харилцааг бүрэн тусгаж өгөөгүй, зарим асуудлыг засгийн газар үүрэг өгөх байдлаар шилжүүлж зохицуулсан байна.	
29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.	
29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.	
29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан	
29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.	
29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан	
29.1.8. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа,	Шаардлага хангасан	

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД БҮРТ ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ БУЮУ
“ХҮҮХДИЙН МӨНГӨ” ОЛГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зэрчсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлага хангагүй, энэ үүргийг Засгийн газар шилжүүлж зохицуулсан
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шат:

Тогтоолын төслийг Засгийн газраас баталсан аргачлалын дагуу үнэлж дараах дүгнэлт, зөвлөмж гаргаж байна. Сонгосон шалгуур үзүүлэлтийн хувьд Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь зорилгод хүрэх байдал нь өндөр, асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой, практикт 2009 оноос 2016 он хүртэл амжилттай хэрэгжиж байсан, иргэд болон хүүхдүүдэд эерэг үр нэлөөтэй шийдвэр тул хүлээн зөвшөөрөгдөх, Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцсэн, ойлгомжтой байдлаар томьёологдсон байна.

---оОо---

Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд 2009 оноос хойш хүүхэд бүрт олгогдож ирсэн "Хүүхдийн мөнгө"-ийг ямар нэгэн ялгаварлал, алагчлалгүйгээр дахин хүүхэд бүрт олгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхийн тулд Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачилж байна.

Монгол Улсын Их Хурал ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэн, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн, иргэддээ тэгш хүртээх зорилгоор 2009 онд "Хүний хөгжил сангийн тухай" хуулийг баталж, энэ хуулийнхаа хүрээнд хүүхэд бүрт ямар нэг ялгаваргүйгээр хүүхдийн мөнгө олгож ирсэн боловч уг хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болохтой холбогдуулан Улсын Их Хурал 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүүхдийн мөнгө олгох арга хэмжээг нийгмийн халамжийн нэг төрөл болгон, хүүхдийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгох болсон.

Хүүхдийн мөнгийг халамжийн нэг төрөл болгон, хүүхдийг өмч хөрөнгө, эд хөрөнгийн байдал, нийгмийн гарлаар нь ялгаварлан мөнгөн тэтгэмж олгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээз, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалт, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хүүхдийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, тэрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй байх, түүнчлэн хүүхдийг гэр бүлийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшлийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчилахгүй байх гэсэн заалттай тус тус зөрчилддөг, иргэд, эцэг эхчүүдийн зүгээс "Хүүхдийн мөнгө"-ийг хүүхэд бүрт олгохыг хүссэн өргөдөл, хүсэлт ихээр ирүүлэх болсон зэрэг нь энэхүү Улсын Их Хурлын тогтоолыг санаачлан боловсруулах үндэслэл болсон юм.

Та энэхүү тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулга, судалгаа болон бусад материалтай танилцаж өөрийн саналаа tusul@president.mn хаягаар ирүүлнэ үү.

Taniltsuulga

Tandan_Sudalgaa1

Togtooliin_Tusliin_Ur_Nuluunii_Sudalgaa2

Togtooliin_Tusul1

Uzel_Barimtlal

Zardliin_Tootsooloj1



2017/12/27 3:04:01

Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт

Tuvshintugs Batsukh
To tusul@president.mn

12/29/2017 1:50 PM 

Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт ялгаварлалгүй олгохыг хүсч байна

Sent from Mail for Windows 10

санал

munkhtur.j
To tusul@president.mn

3/4/2018 9:08 PM

Үе үеийн Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд бүрт хүртээмжтэй болгох, ялангуяа хүүхэд бүр ижил тэгш орчинд өсч хүмүүжих нөхцлийг бүрдүүлэх талаар анхаарал тавин ажиллаж шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн бөгөөд үүний нэг нь хүүхэд, эцэг эхчүүдийн дэмжлэгийг хүлээсэн, эдийн засгийн өсөлт, хямралын аль ч үед хэрэгцээтэй гэдэг нь бодит амьдралдээр туршигдаж, олон улсад сайн жишээгээр нэрлэгдсэн Хүний хөгжил сангийн тухай хуулийн хүрээнд хүүхэд бүрт олгосоор ирсэн "Хүүхдийн мөнгө"-ний бодлого гэж би ойлгодог.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгavarлан гадуурхаж үл болно" гэсэн заал байдаг. Иймд хүүхдийн мөнгийг ялгavarлалгүйгээр цаашид хүүхэд бүрт олгох нь зүйтэй гэж үзэж байна.

Дундговь аймгийн МоАХ-ны дарга Жанлавын Мөнхтөр
2018-03-05

No subject

Batbayar Myagmarsuren
To tusul@president.mn

3/5/2018 4:47 AM

1. Иргэд, эцэг эхчүүдийн зүгээс ч "Хүүхдийн мөнгө"-ийг цаашид хүүхэд бүрт олгохыг маш ихээр хүсч, дэмжиж байна.
2. Хүүхдийн мөнгийг ямар нэгэн ялгаварлал алагчлалгүйгээр хүүхдэд бүрт олгохийг хүсч байна.
3. Хүүхдийн мөнгийг нийгмийн гарал, яс үндэс, амьжиргааны түвшингээр нь ялгаварлан өгөх нь буруу
4. Хүүхдэд хүүхдийн мөнгө олгох, хүүхдийн мөнгөө аваагүй хүүхдүүдэд нөхөж олгох шийдвэр гаргаж өгнө үү. Хүүхдийн мөнгийг олгож өгнө үү.
5. Үндсэн хууль зөрчиж хүүхэд ялгаварлан гадуурхийг болимоор байна.
6. Хүүхэд бүр тэгш эрхтэй байх ёстой
7. Хүүхдүүдийн өөр хоорондын харилцаа холбоо бодох хэрэгтэй
8. Хүүхдийн мөнгийг цаашид хүүхэд бүрт олгохыг маш ихээр хүсч, дэмжиж байна.

Хүүхдийн мөнгний тухай

Zorigtbaatar Battogtokh
To tusul@president.mn

3/6/2018 1:22 AM 

Сар бүр олгодог хүүхдийн мөнгийг нийгмийн гарал, амьжиргааны түвшингөөр нь ялгаварлалгүй олгож өгнө үү.
ялгавартай олгож байгаа буу.

~~No Subject~~
Q
Q
...
Open in browser tab
...
X

B. Bolor
To tusul@preside...

▼ 1 attachment

канал.docx {21.7}

This mail has no c...

Санал

Details
Name: канал.docx
Size: 22 KB
Modified: -
Tusul
Shares: -

2018 7:16 PM



1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний нэг болох НҮБ-ын "Хүүхдийн эрхийн тухай конвенц"-тэй зөрчилдэж байна. Иргэд, эцэг эхчүүдийн зүйзэс ч "Хүүхдийн мөнгө"-ийг цаашид хүүхэд бүрт олгохыг маш ихээр хүсч, дэмжих байна.
2. Хүүхдэд хүүхдийн мөнгө олгох, хүүхдийн мөнгөө аваагүй хүүхдүүдэд нэхж олгох шийдвэр гаргаж өгнө үү. Хүүхдийн мөнгийг олгож өгнө үү.
3. Хүүхдийн мөнгийг ямар нэгэн ялгаварлал алагчлалгүйгээр хүүхдэд бүрт олгохийг хүсч байна.
4. Ye үеийн Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд бүрт хүртээмжтэй болгох, ялангуяа хүүхэд бүр ижил тэгш орчинд есч хүмүүжих нэхцлийг бүрдүүлэх талаар анхаарал тавин ажиллаж шат дараатай арга хэмжээг хэрэгкүүлж ирсэн бөгөөд үүний нэг нь хүүхэд, эцэг эхчүүдийн дэмжлэгийг хүлээсэн, эдийн засгийн есelt, хямралын аль ч үед хэрэгцээтэй гэдэг нь бодит амьдрал дээр туршигдах, олон улсад сайн жишээгээр нэрлэгдсэн Хүний хөгжил сангийн тухай хуулийн хурээнд хүүхэд бүрт олгосоор ирсэн "Хүүхдийн мөнгө"-ний бодлого юм.
5. Хүүхдийн мөнгийг нийгмийн гарал, яс үндэс, амьжиргэаны түвшингөөр нь ялгаварлан өгөх нь буруу иймд хүүхдийн мөнгийг олгож өгөхийг дэмжих өгнө үү.
6. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заал байдаг. Иймд хүүхдийн мөнгийг ялгаварлалгүй олгох нь зүйтэй гэж үзэж байна.
7. Хүүхдийн мөнгийг цаашид хүүхэд бүрт олгохыг, дэмжих байна.

Монгол Улсын Иргэн хүүхэд бүрт халамжийг тэгш хүртээ санал

Open in browser tab

narantssetseg tsere
To tusul@president.mn

▼ 1 attachment

2018.3.6. санал ир

This mail has no cor

Санал:

Монгол Улсын Үндсэн хуулиар "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө,
нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан
тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор чь ялгаварлан
гадуурхаж үл болно" гэж байдаг гэсэн Иймд хүүхдийг ялгаварлалгүйгээр
халамж үзүүлж мэнгэн тусlamжийг хүүхэд бүрт олгох нь зүйтэй гэж үзэж
байна.

СХД-ийн 10 дугаар хорооны иргэн. ахмад Цэрэндоржийн Наранцэцэг

Утас 89906798

Details

5/2018 7:28 PM

Name

2018.3.6. санал иргэн.docx

Size

20 KB

Modified

-

Tusul

Shares